

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/71/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99900662 Цахим хаяг:
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг:
davaanyamb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
4. Аудитын тайлан	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

АДЗ.Од.13 № 01/63
танай _____-ны № _____-т

ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ж.БААСАНЖАВ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чандмань-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чандмань-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд ОНХС-ийн хөрөнгөөр 71,360.0 мянган төгрөгийн ковш, 24,581.2 мянган төгрөгийн өртөгтэй дэд станц, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 182,000.0 мянган төгрөгийн хөдөө аж ахуйн трактор тоног төхөөрөмж зэрэг хөрөнгүүдийг хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Байгууллагын төсвөөс бэлэг дурсгалын зүйл худалдан авч 927.0 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан зөрчил илэрсэн.

Бусад асуудлын хэсэг

Засаг даргын Тамгын газрын дарга нь сумын Засаг даргатай 2022 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 90.5 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	82,511,421.00	139,030,024.00
33	АВЛАГА	22,877.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	22,877.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	82,488,544.00	139,030,024.00
354	Хангамжийн материал	80,378,544.00	136,740,024.00
35410	Бичиг хэргийн материал	279,000.00	279,000.00
35420	Аж ахуйн материал	197,600.00	197,600.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,812,140.00	5,010,140.00
35440	Түлш, шатах тослох материал	4,815,000.00	7,906,250.00
35470	Бусад хангамжийн материал	70,274,804.00	123,347,034.00
35600	Мал амьтад	2,110,000.00	2,290,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	795,010,592.70	1,068,180,652.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	795,010,592.70	1,068,180,652.04
392	Биет хөрөнгө	712,348,842.70	982,068,943.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	493,042,781.41	502,142,781.41
39202	Хуримтлагдсан элэгдэл	-89,610,188.68	-114,787,803.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	95,053,133.48	154,248,717.48
39204	Хуримтлагдсан элэгдэл	-32,145,987.89	-26,684,753.35
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	119,547,036.88	325,587,888.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	-34,929,065.66	-39,966,327.46
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,281,362.07	44,895,141.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,153,510.52	-9,081,234.24
39209	Зам, гүүрийн байгууламж	25,000,000.00	25,000,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-5,416,667.04	-7,583,333.76
39214	Бусад үндсэн хөрөнгө	178,760,025.24	200,335,719.65
39215	Хуримтлагдсан элэгдэл	-57,080,076.59	-72,037,853.13
393	Биет бус хөрөнгө	82,661,750.00	86,111,708.36
39301	Програм хангамж	3,885,000.00	3,285,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,031,250.00	-1,157,291.64
39303	Бусад биет бус хөрөнгө	79,808,000.00	83,984,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	877,522,013.70	1,207,210,676.04
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	877,522,013.70	1,207,210,676.04
51	Засгийн газрын хувь оролцоо	877,522,013.70	1,207,210,676.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	328,932,829.60	328,932,829.60
51101	Өмч: - төрийн	328,932,829.60	328,932,829.60
512	Хуримтлагдсан үр дүн	237,129,185.15	566,817,847.49
51210	Өмнөх үеийн үр дүн	237,129,185.15	237,129,185.15
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	329,688,662.34
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	311,459,998.95	311,459,998.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	877,522,013.70	1,207,210,676.04

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	534,106,296.35	940,117,126.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	107,107,055.35	408,999,326.00
120	Нийтлэг татварын бус орлого	107,107,055.35	408,999,326.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,000,000.00	408,999,326.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,448,100.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	407,551,226.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	426,999,241.00	531,117,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,921,541.00	3,490,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,626,500.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,315,041.00	3,210,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	980,000.00	280,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	421,077,700.00	527,627,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	421,077,700.00	527,627,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	475,402,616.16	604,278,069.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	475,402,616.16	604,278,069.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	421,717,955.75	520,935,588.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	245,834,172.68	264,509,256.74
210101	Үндсэн цалин	245,834,172.68	264,509,256.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,575,646.91	33,873,069.48
210201	Тэтгэврийн даатгал	22,949,886.91	23,311,141.48
210202	Тэтгэмжийн даатгал	2,458,419.00	2,644,970.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,966,735.00	2,115,979.00
210204	Ажилгүйдлийн даатгал	472,783.00	527,361.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,727,823.00	5,273,618.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,671,284.00	13,805,140.56
210301	Гэрэл, цахилгаан	3,276,284.00	4,396,390.56
210302	Түлш, халаалт	8,395,000.00	9,408,750.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,425,993.00	28,544,565.00
210401	Бичиг хэрэг	2,609,700.00	2,667,860.00
210402	Тээвэр, шатахуун	13,980,740.00	16,989,310.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,031,602.00	2,994,200.00
210404	Ном, хэвлэл	164,840.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,300,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	1,525,425.00
210408	Бараа материал акталсны зардал	1,539,111.00	4,367,770.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,840,600.00	2,794,200.00
210604	Урсгал засвар	2,840,600.00	2,794,200.00
2107	Томиллолт, зочны зардал	4,000,000.00	4,000,000.00
210702	Дотоод албан томиллолт	4,000,000.00	4,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,725,757.00	25,199,534.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,278,600.00	22,837,160.00
210803	Даатгалын үйлчилгээ	188,900.00	188,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	123,948.00	113,474.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	584,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	495,309.00	1,565,000.00

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	91,644,502.16	148,209,822.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,483,086.00	53,650,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,460,100.00	2,279,750.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	60,701,316.16	92,279,272.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,684,660.41	83,342,481.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,968,300.00	28,230,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	17,863,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,972,300.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,996,000.00	10,367,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	34,716,360.41	55,111,781.22
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,716,360.41	55,111,781.22
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	58,703,680.19	335,839,056.67
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,800,000.00	6,150,394.33
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	7,800,000.00	6,150,394.33
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-7,800,000.00	-6,150,394.33
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	50,903,680.19	329,688,662.34

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	427,499,241.00	532,565,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	500,000.00	1,448,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	500,000.00	1,448,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	500,000.00	1,448,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	1,448,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	426,999,241.00	531,117,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,921,541.00	3,490,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,626,500.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,315,041.00	3,210,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	980,000.00	280,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	421,077,700.00	527,627,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	421,077,700.00	527,627,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	411,581,641.00	522,265,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	411,581,641.00	522,265,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	358,106,980.59	439,290,918.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	245,834,172.47	264,489,604.11
210101	Үндсэн цалин	201,666,199.85	216,118,831.39
210102	Нэмэгдэл	44,167,972.62	34,245,165.92
210104	Урамшуулал	00.00	14,125,606.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,598,524.12	33,778,195.11
210201	Тэтгэврийн даатгал	22,876,552.78	23,032,098.58
210202	Тэтгэмжийн даатгал	2,534,018.25	2,702,083.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,997,074.60	2,148,506.70
210204	Ажилгүйдлийн даатгал	431,456.39	535,159.52
210205	Эрүүл мэндийн даатгал	4,759,422.10	5,360,346.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,376,284.00	16,896,390.56
210301	Гэрэл, цахилгаан	3,276,284.00	4,396,390.56
210302	Түлш, халаалт	9,100,000.00	12,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,886,882.00	24,176,695.00

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	2,609,700.00	2,667,860.00
210402	Тээвэр, шатахуун	13,980,740.00	16,989,210.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,031,602.00	2,994,200.00
210404	Ном, хэвлэл	164,840.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,300,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	1,525,425.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,495,600.00	2,992,200.00
210604	Урсгал засвар	2,495,600.00	2,992,200.00
2107	Томилолт, зочны зардал	4,000,000.00	4,000,000.00
210702	Дотоод албан томилолт	4,000,000.00	4,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,685,857.00	31,241,184.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,282,700.00	28,878,810.00
210803	Даатгалын үйлчилгээ	195,900.00	188,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	116,948.00	113,474.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	540,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	495,309.00	1,565,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,229,661.00	61,716,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,680,561.00	59,436,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,549,100.00	2,279,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,474,660.41	82,974,981.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,758,300.00	27,863,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	17,863,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,972,300.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,786,000.00	10,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	34,716,360.41	55,111,781.22
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,716,360.41	55,111,781.22
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	15,917,600.00	10,300,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	15,917,600.00	10,300,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,917,600.00	10,300,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,917,600.00	10,300,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,917,600.00	10,300,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-15,917,600.00	-10,300,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Лөгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	328,932,829.60	311,459,998.95	237,129,185.15	00.00	877,522,013.70
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	328,932,829.60	311,459,998.95	237,129,185.15	00.00	877,522,013.70
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	328,932,829.60	311,459,998.95	237,129,185.15	00.00	877,522,013.70
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	329,688,662.34	00.00	329,688,662.34
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	328,932,829.60	311,459,998.95	566,817,847.49	00.00	1,207,210,676.04

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	527,627,800.00	473,999,118.78	53,628,681.22	89.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	527,627,800.00	473,999,118.78	53,628,681.22	89.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	499,764,600.00	446,135,918.78	53,628,681.22	89.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	269,850,600.00	264,489,604.11	5,360,995.89	98.0
210101	Үндсэн цалин	269,850,600.00	216,118,831.39	53,731,768.61	80.1
210102	Нэмэгдэл	00.00	34,245,165.92	-34,245,165.92	
210104	Урамшуулал	00.00	14,125,606.80	-14,125,606.80	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,643,400.00	33,778,195.11	7,865,204.89	81.1
210201	Тэтгэврийн даатгал	29,480,500.00	23,032,098.58	6,448,401.42	78.1
210202	Тэтгэмжийн даатгал	3,913,000.00	2,702,083.50	1,210,916.50	69.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,199,900.00	2,148,506.70	51,393.30	97.7
210204	Ажилгүйдлийн даатгал	550,100.00	535,159.52	14,940.48	97.3
210205	Эрүүл мэндийн даатгал	5,499,900.00	5,360,346.81	139,553.19	97.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,500,000.00	16,896,390.56	603,609.44	96.6
210301	Гэрэл, цахилгаан	5,000,000.00	4,396,390.56	603,609.44	87.9
210302	Түлш, халаалт	12,500,000.00	12,500,000.00	00.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	24,180,000.00	24,176,695.00	3,305.00	100.0
210401	Бичиг хэрэг	2,500,000.00	2,667,860.00	-167,860.00	106.7
210402	Тээвэр, шатахуун	16,990,000.00	16,989,210.00	790.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,940,000.00	2,994,200.00	-54,200.00	101.8
210404	Ном, хэвлэл	250,000.00	00.00	250,000.00	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,525,425.00	-25,425.00	101.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,000,000.00	2,992,200.00	6,007,800.00	33.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	00.00	6,000,000.00	0.0
210604	Урсгал засвар	3,000,000.00	2,992,200.00	7,800.00	99.7
2107	Томилолт, зочны зардал	4,000,000.00	4,000,000.00	00.00	100.0
210702	Дотоод албан томилолт	4,000,000.00	4,000,000.00	00.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,636,700.00	37,431,184.00	12,205,516.00	75.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,158,700.00	35,068,810.00	12,089,890.00	74.4
210803	Даатгалын үйлчилгээ	238,000.00	188,900.00	49,100.00	79.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	113,474.00	6,526.00	94.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00	00.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	440,000.00	60,000.00	88.0
210807	Газрын төлбөр	1,565,000.00	1,565,000.00	00.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83953900.00	62371650.00	21,582,250.00	74.3

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,453,900.00	60,091,900.00	21,362,000.00	73.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500,000.00	2,279,750.00	220,250.00	91.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27863200.00	27863200.00	00.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,863,200.00	27,863,200.00	00.00	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,863,200.00	17,863,200.00	00.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,000,000.00	10,000,000.00	00.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	527,627,800.00	473,999,118.78	53,628,681.22	89.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	527,627,800.00	472,551,018.78	55,076,781.22	89.6
132001	Орон нутгийн төсвөөс	527,627,800.00	472,551,018.78	55,076,781.22	89.6
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	1,448,100.00	-1,448,100.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,448,100.00	-1,448,100.00	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	24.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	08.00	08.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	00.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3,455,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,455,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,455,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,910,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,910,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		545000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		545,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		3455000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		3,455,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,175,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		280,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Чандмань-Өндөр сумын ЗДТГ нь тухайн орон нутагт хууль журамд заасан чиг үүрийг орон нутагт хэрэгжүүлэх, ард иргэдийг мэдээллээр хангах үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна. Тус байгууллага нь 2022 онд дараах зорилтуудыг тавьж ажилласан байна. Үүнд:

- ИТХ, засаг даргад үзүүлэх үйлчилгээ, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг тооцон гаргах
- Ард иргэдэд чиглэсэн үйлчилгээг хөнгөн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилт
- Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлт, байгаль орчны талаар байгууллагын стратеги зорилт
- Эдийн засаг, төсөв санхүү, орлого татвар, худалдан авах ажиллагааны талаар байгууллагын стратегийн зорилт
- Нийгмийн халамж, иргэний бүртгэл, нийгмийн даатгалын талаар байгууллагын стратеги
- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах зэрэг зорилтуудыг давьж хэрэгжүүлэн ажилласан байна.

ЗДТГ-ын дарга нь нь сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 90.5 хувьтай биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль болон бусад хууль тогтоомж журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой байгууллагын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг баримталж ажилласан байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу ЗДТГ-ын даргын 2020 оны 06 сарын 17 өдрийн А/17 тоот тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын баг байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан цаг ашиглалт, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зарцуулалтад дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын нэг, хоёрдугаар үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу ЗДТГ-ын дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Чандмань-Өндөр сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсрол, соёлын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Чандмань-Өндөр сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 329,688.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	82,488.5	139,030.0	56,541.5
Үндсэн хөрөнгө	795,010.6	1,068,180.7	273,170.1
Нийт хөрөнгө	877,522.0	1,207,210.7	329,688.7
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	-	-	-
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	877,522.0	1,207,210.7	329,688.7

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал данс өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Бараа материалын дансны үлдэгдэл нэмэгдсэн шалтгаан нь үнэ аймаг орон нутгийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө материал нэмэгдсэнтэй холбоотой. ОНХС-аар 40,000.0 мянган төгрөгийн өртөгтэй ЗДТГ-ын зураг төсөв, Ойн хандиваас 5,000.0 мянган төгрөгийн өртөгтэй 250 ширхэг тус сумын түүхийн ном зэрэг 45,721.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэнтэй холбоотой байна.
2. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нэмэгдсэн нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар 12,038.0 мянган төгрөгийн 4 мотоцикл, ОНХС-ийн хөрөнгөөр 71,360.0 мянган төгрөгийн ковш, улсын хөрөнгө оруулалтаар 182,000.0 мянган төгрөгийн хөдөө аж ахуйн трактор тоног төхөөрөмж, ОНХС-аар 19,000.0 мянган төгрөгийн өртөгтэй гэр, 24,581.2 мянган төгрөгийн өртөгтэй дэд станц зэрэг хөрөнгүүд нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 436,132.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн санал дээр 91,495.5 мянган төгрөгийн төсвийг нэмж баталсан байна. Энэ нь тогтмол зардлын өртөг нэмэгдсэн, Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал, шүлхий өвчинтэй тэмцэх орон нутгийн нөөцийн зардлыг нэмж баталсан зэрэгтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 76,768.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 527,627.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 472,551.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоос 1,448.1 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 473,999.1 мянган төгрөг буюу 89.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 43,604.5 мянган төгрөгөөр, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 8,721.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт %
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	481,566.7	439,410.3	42,156.4	91.2
2	Байгаль орчин хамгаалах нөхөн сэргээх	46,061.1	34,588.8	11,472.2	75.0
	Дүн	527,627.8	473,999.1	53,628.7	89.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 2,910.0 мянган төгрөг, аймгийн ИТХ-аас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн хамтарсан багийн дэмжлэгт 300,0 мянган төгрөг олгосон бөгөөд цахим тендерийн бичиг баримтын үнэ 280,0 мянган төгрөгийг нийт 3,445.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 2,910.0 мянган төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 545.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Чандмань-Өндөр сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Чандмань-Өндөр сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 1/06 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 1.5 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 7,131.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5,704.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь Цалин шимтгэлийн зардлыг 13,226.2 мянган төгрөгөөр, Эд хогшил, урсгал засварын зардлыг 6,007.8 мянган төгрөгөөр, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 12,205.5 мянган төгрөгөөр, Бараа үйлчилгээний бусад зардлыг 21,582.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

Тус байгууллагад Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 29 асуудлаар горим сорилыг хэрэгжүүлсэн. Горим сорилыг хэрэгжүүлэх явцад байгууллагын төсвөөс 927.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авч зарцуулсан зөрчил илэрсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна..

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Чандмань-Өндөр сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 58,171.0 мянган төгрөгийн зөрчилд 771.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 57,400.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	771.0	1	771.0	100
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	1	57,400.0	1	57,400.0	100
Нийт дүн	2	58,171.0	2	58,171.0	100

/мянган төгрөгөөр/

Өмнөх онд тогтоосон 771.0 мянган төгрөгийн төлбөрийн 1 акт, 57,400.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 206,504.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн. Аудитын явцад 205,577.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг, хандив тусламжаар хүлээн авсан гэж буруу бүртгэсэн алдааг залруулж, 927.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосон.

5.1 Төлбөрийн акт

- Байгууллагын төсвөөс 927.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалттай тус тус нийцэхгүй байгаа бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Иймд 927.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага хариуцлага тооцох санал хүргүүлээгүй болно.

5.3 Зөвлөмж

Аудитаар ямар нэгэн зөвлөмж өгөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн алдаа	1	205.577.0			1	205.577.0	1	205.577.0				
Дүн	1	205.577.0			1	205.577.0	1	205.577.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой	1	927.0	1	927.0								
Дүн	1	927.0	1	927.0								

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

БАТАЛГААЖУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЫМ ОГНОО:

